

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ 2020 ОНД БАЙГУУЛСАН
ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ**

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Суурь түвшин	2020 онд хүрэх үр дүн	Хэрэгжилт	Үнэлгээ
Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээ					
1	Сум дундын малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарын лаборатори /Өмнөговь, Булган, Сэврэй, Мандал-Овоо сум/	0	Санхүүжилт бүрэн хийгдэж, ажил дууссан байна	Булган, Сэврэй, Мандал-Овоо суманд малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний чанарын лабораторид шаардлагатай тоног төхөөрөмжийг нийлүүлэх гүйцэтгэчийг сонгон шалгаруулж, "Синапс" ХХК-тай 175475300 төгрөгөөр гүйцэтгэх гэрээ байгуулан 100 хувь гүйцэтгэж, Булган, Сэврэй, Мандал-Овоо сумдад бүрэн хүлээлгэн өгсөн. Даланзадгад суманд байгуулагдсан Хүнсний иж бүрэн лабораторийн барилгын гүйцэтгэлийг 100% хийлгэж, байнгын ашиглалтад оруулсан.	100
2	Услалтын системийг шинэчлэх, шинэ технологи нэвтрүүлэх /Өмнөговь/	0	Санхүүжилт бүрэн хийгдэж, ажил дууссан байна	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх Услалтын системийг шинэчлэх, шинэ технологи нэвтрүүлэх ажил нь мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн зураг төсөв байхгүйгээс шалтгаалан хугацаа хоцорч, төсөв хасагдсан. Аймгийн хэмжээнд орон нутгийн өмчийн 13 услалтын систем /Баяндалай сумын Баян, Наран, Булган сумын Булганбулаг, Хадат, Дал, Гурвантэс сумын Хуршуут, Номгон сумын Эрдэнэбулаг, Баянбулаг, Ханхонгор сумын Нарийн, Шавартай, Хадат, Балгасны гол, Даланзадгад сумын Далан/ байдаг. Ашиглах боломжтой га талбай нь 338 га талбай бөгөөд үүнээс ашиглаж байгаа нь 161,7 га талбай байна. Услалтын системүүдийг засварлаж, ашиглалтын хүчин чадлыг нэмэгдүүлэхээр аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд 2020 оны үндсэн чиглэлд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт 800,0 сая төгрөг төсөвлөснөөр Гурвантэс сумын Хуршуут, Ханхонгор сумын Нарийн, Булган сумын Булган, Номгон сумын Баянбулаг услалтын системийг тус тус засварлаж 39.25 га талбайгаар тариалах талбайг, 64 орчим га талбайгаар услах хүчин чадлыг нэмэгдүүлсэн. Тус бүртгэлтэй услалтын системүүдийг бүрэн паспортжуулсан.	Үнэлэх боломжгүй
3	Хөдөө аж ахуйн дундын техник үйлчилгээний төвийн явуулын барилга,	0	Санхүүжилт бүрэн хийгдэж, ажил дууссан байна	Тус ажил нь 2020-2021 онуудад дамжигдан хийгдэхээр санхүүжилтийн хуваарилагдсаны дагуу 2020 оны төсөвт суугдсан хөрөнгөөр Хөдөө аж ахуйн дундын техник үйлчилгээний төвийн явуулын барилга, тоног төхөөрөмж /багц-1/, Хөдөө аж ахуйн	

	тоног төхөөрөмж /Өмнөговь, Булган сум/			<p>дундын техник үйлчилгээний төвийн барилга байгууламж /багц-2/ болгон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу гүйцэтгэчийг сонон шалрагуулсан. Сонгон шалгаруулалтад Хөдөө аж ахуйн дундын техник үйлчилгээний төвийн явуулын барилга, тоног төхөөрөмж /багц-1/ ажлын гүйцэтгэгчээр "Бэст агро интернэйшнл" ХХК шалгарч 1098248170 /нэг тэрбум ерэн найман сая хоёр зуун дөчин найман мянга нэг зуун дал/ төгрөгийн дүн бүхий гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн. Гүйцэтгэгч "Бэст агро интернэйшнл" ХХК нь гэрээт ажлаа хугацаанд нь гүйцэтгэж, ашиглагч байгууллагад бүрэн хүлээлгэж өгсөн.</p> <p>Хөдөө аж ахуйн дундын техник үйлчилгээний төвийн барилга байгууламж /багц-2/ ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах ажилдлагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 2 удаа зохион байгуулагдсан боловч 2021 онд санхүүжигдэхээр төлөвлөгдсөн тул оролцогч ирээгүйн дээр УЛСЫН 2020 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ хуулиар батлагдсан төсөв цуцлагдсан. Тус хуулийн өөрчлөлтөөр Дээрх ажлын гүйцэтгэлд 600.0 сая төгрөг төсөвлөгдсөн нь Хөдөө аж ахуйн дундын техник үйлчилгээний төвийн явуулын барилга, тоног төхөөрөмж /багц-1/ ажлын гүйцэтгэлийн санхүүжилтийн 50 хувийг олгод байна.</p>	100
4	Шинэ хөдөө төсөл /Өмнөговь, Гурвантэс сум/	0	Санхүүжилт бүрэн хийгдэж, ажил дууссан байна	<p>Гурвантэс сумын Засаг даргын Тамгын газар "Шинэ хөдөө төсөл"-ийг хэрэгжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолтыг боловсруулан, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу гүйцэтгэчийг сонгон шалгаруулж "Гранд экстернал инвестор" ХХК-тай ӨМАГТСЗДТГ/2020/17 дугаар бүхий 112 669 000 /нэг зуун арван хоёр сая зургаан зуун жаран есөн мянга/ төгрөгийн дүнтэй гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн.</p> <p>Гүйцэтгэгч "Гранд экстернал инвестор" ХХК нь гэрээт ажлаа хугацаанд нь бүрэн гүйцэтгэж ашиглагч байгууллагад хүлээлгэн өгсөн. Шинэ хөдөө төслийн хүрээнд 18 нэр төрлийн 23 ш тоног төхөөрөмжийг 4 иргэн, 3 аж ахуйн нэгжид хүлээлгэн өгөөд байна. Үүний үр дүнд иж бүрэн бууз баншны цех, эсгийний үйлдвэр, Хулдаасан хэвлэлийн үйлдвэр, хэрчсэн гурилын цех гэх мэт жижиг дунд үйлдвэрлэлүүд нэмэгдэж 10 ажлын байр хадгалагдан, 6 ажлын байр шинээр бий болсон байна.</p>	100
Мал аж ахуйн салбарын чиглэлээр					
5	Малыг ялган тэмдэглэж, бүртгэлжүүлэх, малын	Бүртгэл мэдээллийн нэгдсэн санд 74.073	Аймгийн нийт мал сүргийн 10%-ийг ялган тэм дэглэж,	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны А-122 дугаар тушаалын дагуу "Мал сүрэгт үзлэг ангилалтын ажил зохин байгуулах тухай" аймгийн Засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын	30

	бүртгэл мэдээллийн нэгдсэн санд хамруулах	мянган мал бүртгэгдсэн байна	мэдээллийн нэгдсэн санд хамруулсан байна	<p>15-ны А/389 дүгээр захирамж гарган аймгийн хэмжээнд Галбын говийн улаан үүлдрийн 2015 тэмээ, Ханын хэцийн хүрэн үүлдрийн 1154 тэмээ, Говь гурван сайхан үүлдрийн 2416 ямаа, нутгийн шилмэл сүрэг Цогт-Овоогийн улаан 2013 ямаа, Гавилууд 3010 хонь нийт 10608 толгой малд үзлэг ангилалт хийж 4 аж ахуй нэгжтэй гэрээ байгуулан ангилалтын ажил технологит хугацаанд нь хийж гүйцэтгэсэн. Ангилалтад хамрагдсан малыг эзэмгэлэх ажил давхар хийгдсэн ба бүртгэл мэдээллийн санд орууллаа.</p> <p>Аймгийн хэмжээнд үржилд ашиглаж байгаа бог малын хээлтүүлэгчийг 100% эзэмгэлэн бүртгэлжүүлэхээр "Тэргүүн сүрэг" ХХК-аас 10088 ширхэг ээмгийг гэрээгээр авч сумдад хүргүүлсэн боловч орон нутгийн зуншлага, намаржилт тааруу, отор нүүдэл нэмэгдсэнтэй холбоотойгоор ээмэгжүүлэх ажил удаашралтай явагдаж байна. Ханбогд суманд үржүүлэгддэг нутгийн шилмэл сүрэг болох Гавилууд хонины 5000 хонь, Гурвантэс сумын Тостын цагаан ямааг 2100, 5 сумын 1380 бог малын хээлтүүлэгчийг ээмгэлж, 2020 онд 8480 мал эзэмгэлэн мэдээллийн нэгдсэн санд бүртгэж, мэдээллийн нэгдсэн санд нийт 82553 мал бүртгэсэн ба нийт мал сүргийн 2,7 хувийг эзэлж байна.</p>	
6	Бэлчээрийн даацаас илүү гарсан малыг эдийн засгийн эргэлтэд оруулах	2019 онд 3000.2 мянган толгой мал тоолуулсан. 6.1 мянган мал хорогдсон	Таваарын малын 30-иас доошгүй хувийг болон ангилалтаар үржилд тэнцээгүй малыг эдийн засгийн эргэлтэд оруулж малын зүй бус хорогдлын оны эхний нийт малд эзлэх хувийг өмнөх оноос бууруулсан байна.	<p>2020 оны эхний 11 сарын байдлаар 4,3 мянган толгой том малын зүй бусын хорогдол гарсан нь оны эхний нийт малын 0.1 хувийг эзэлж байгаа дүнтэй байна.</p> <ul style="list-style-type: none"> • Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 200 хонь бордох аж ахуйг Булган суман дахь Хөдөө аж ахуйн дундын техник үйлчилгээний төвийг түшиглэн барьж ашиглалтад оруулахаар төлөвлөн зураг төсөв боловруулан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж "Тангад ара" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж байна. • Малын төрөл хоорондын зохистой түвшинд хүргэх зорилгоор орон нутгийн малжуулах төслийг хоньжуулах төсөл болгон хэрэгжүүлэхээр төслийг боловсруулаад байна. Төсөл хэрэгжсэнээр хонь цөөтэй, хонь өсгөх зорилготой малчдад төллөх насны үржлийн хонийг маллуулж, хонин сүргийн тоо толгойг өсгөх бодлого хэрэгжүүлнэ. • 2021 оны хавар зуны улирлын Өмнөговь аймгийн хүн амын махны хэрэглээний нөөц бүрдүүлэх зорилгоор 200 тонн чанар, стандартын шаардлага хангасан I, II дугаар зэргийн мах бэлтгэн нөөцлөх, орон нутгийн мал аж ахуйн өвөлжилтийн нөхцөл байдалтай уялдуулан дундаас доош тарга хүчтэй 10000 толгой буюу 130 тн мал мах бэлтгэлийн ажлыг орон нутгийн мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрүүдтэй хамтран зохион байгуулж байгаа ба нөөцөд бэлтгэсэн болон дундаас доош тарга 	70

				<p>хүчтэй мал мах бэлтгэсэн аж ахуй нэгжүүдэд бэлтгэсэн махны килограмм тутамд 1000 төгрөгийн урамшуулал олгохоор шийдвэрлэн орон нутгийн төсвөөс 330.0 сая төгрөгийг төсөвлөн зарцуулаад байна.</p> <ul style="list-style-type: none"> • Орон нутгийн "Гүүд рүүд интер трейдинг" ХХК, "Хийморийн оюут" ХХК, "Цонлха", "Лусын сэржим" хоршоод зэрэг махны үйлдвэрүүд нь орон нутгаас 137 тн махыг стандартын дагуу бэлтгэн ХХААХҮЯамтай бодлогын гэрээтэй "Ихэр шарангад" ХХК, "Ду юан хаа" ХХК-иудад нийлүүлээд байна. • Мөн 15 сумын 270000 толгой малыг хүнсэнд болон зах зээлд борлуулж, цаг хүндэрсэн Хүрмэн, Баяндалай, Булган сумдын малчид 2400 ямааг өвсөөр сольж эдийн засгийн эргэлтэнд оруулсан байна. Эдийн засгийн эргэлтэд оруулсан мал нийт малын 9%-ийг эзэлж байна. 	
7	<p>Үржилд ашиглаж буй хуц, ухна бухыг удам зүйн үнэлгээний нэгдсэн программд бүртгэх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулах</p>	<p>Программын сургалт хийж, сумдад программыг суулгаж программд бүртгэж эхэлсэн байна</p>	<p>Аймгийн хэмжээнд үржилд ашиглаж байгаа бог малын хээлтүүлэгч болон бухын 50-иас доошгүй хувийг удам зүйн үнэлгээнд оруулсан байна</p>	<p>Аймгийн хэмжээнд үржилд ашиглаж байгаа бог малын хээлтүүлэгчийг 100% ээмэглэн бүртгэлжүүлэхээр "Тэргүүн сүрэг" ХХК-аас 10088 ширхэг ээмгийг гэрээгээр авч сумдад хүргүүлсэн. Аймгийн хэмжээнд зуншлага, намаржилт тааруу болж, отор нүүдэл нэмэгдсэнтэй холбоотойгоор ээмэгжүүлэх ажил удаашралтай явагдаж байна. Аймгийн хэмжээнд Ханбогд суманд үржүүлэгддэг нутгийн шилмэл сүрэг болох Гавилууд хонины 5000 хонь, Гурвантэс сумын Тостын цагаан ямаа 2100, 5 сумын 1380 бог малийн хээлтүүлэгчийг ээмэглэж, нийт 8480 мал ээмэглэн мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн байна. Үнэлгээний нэгдсэн программыг бүх суманд хүлээлгэн өгсөн. Ангилалтад хамрагдсан малыг ээмэглэх ажил давхар хийгдсэн ба бүртгэл мэдээллийн санд бүртгэн ажилласан. Удам зүйн үнэлгээний нэгдсэн программын сургалтыг орон нутагтаа зохион байгуулж, сумдын хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтнүүдийг хамруулах хүсэлтийг ХХААХҮЯамны Малын генетик нөөцийн хэлтэст хүргүүлсэн, шийдвэрлэгдээгүй байна.</p>	30
8	<p>Сум дундын отрын бүс нутаг байгуулах</p>	<p>ажил хийгдээгүй</p>	<p>Нийт бэлчээрийн 10 хүртэл хувийг орон нутгийн тусгай хэрэгцээнд авч сум дундын отрын бүс нутаг байгуулах шийдвэр гаргасан байх</p>	<p>Өмнөговь аймгийн хэмжээнд 3030.0 мянган га газрыг отрын бэлчээр болгох шийдвэр 2003 онд батлагдсан ба отрын бэлчээрийн хил заагийг дахин тогтоох, сумын хэмжээний бэлчээрийн 10-аас доошгүй хувийг отрын нөөц бэлчээрээр бүртгэх чиглэлийг сумдын хөдөө аж ахуйн тасагт албан бичгээр хүргүүлж, тухайн сумын хэмжээнд отрын нөөцөөр бүртгэх боломжтой газрын судалгааг авсан. Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны А-153 дугаар тушаалын дагуу томилогдсон ажлын хэсэг 6 дугаар сард аймгийн отрын бэлчээрийн хил заагийг тодорхойлон, аймаг дундын отрын бүс нутгийг Мандал-Овоо, Цогт-Овоо сумдад байгуулах асуудлаар</p>	100

				Дундговь аймагтай хамтран хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Сум дундын отрын бүсэд Цогт-Овоо сумын нутагт орших Далангийн нурууг бүхэлд нь, Манлай сумаас урагш 80км зайд орших Жаргалант багийн Нураачийн газрыг, Цогтцэций сумын Далангийн зоо, Баяндалай сумын Наран багийн Элгэн, Хилийн зурвас газрын /1,6 сая га/ отрын бүс нутгийг хэвээр үлдээхээр санал нэгдэж, сум дундын отрын бүс нутгийн бэлчээр, бэлчээрийн хэв шинжийг тодорхойлох, отрын бэлчээрийн хил заагийг баталгаажуулж, газрын нэгдмэл мэдээллийн санд оруулахаар болж, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газарт хамтран ажиллах хүсэлтийг хүргүүлсэн. Аймгийн хэмжээнд 3.030 мян га бэлчээрийг буюу нийт бэлчээрийн 10 %-ийг сум дундын отрын бүс нутаг байгуулахаар шийдвэрлэсэн.	
Газар тариалангийн салбарын чиглэлээр					
9	“Атар 4” тариалангийн тогтвортой хөгжлийн аяны төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллах	Атрын 3 дахь аян үндэсний хөтөлбөрийг дүгнэсэн	"Атар 4" тариалангийн тогтвортой хөгжлийн аяны төлөвлөгөөг батлуулж, 2020 онд хийсэн ажлыг дүгнэж ирүүлэх	<ul style="list-style-type: none"> • “Атар-4” аяны 8 зорилтын хүрээнд 31 арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөн 95%-тай хэрэгжүүлсэн. • Ханбогд суманд 220 м.кв 1 ширхэг, Гурвантэс суманд 600 м.кв 2, нийт 1420 м.кв бүхий талбайтай 3 ширхэг өвлийн хүлэмжийг ашиглалтад оруулаад байна. • Аймгийн хэмжээний 15 сумын газар тариалан эрхлэгчдэд 9000 орчим хүнсний ногооны үрслэгийг Даланзадгад сумын "Хүлэмжийн цогцолбор аж ахуйн талбай"-д байрлах өвлийн хүлэмжинд бойжуулан сумдад хуваарилан олгосон. • 2020 онд "Монгол ногоо", “Гала” сортын төмсний үрийн захиалгыг авч нийт 10 тн нэгдүгээр репордукцийн үрийг газар тариалан эрхлэгчдэд нийлүүлсэн. ХХААХҮЯамнаас 7 нэр төрлийн 100 орчим кг хүнсний ногооны үр буцалтгүй тусламжаар олгосон. Мөн "Хүнсний ногоо" үндэсний хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэхээр орон нутгаас 3.0 сая төгрөг шийдвэрлэж хүнсний ногоо “Хатаах тоног төхөөрөмж”-ийг авч газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хоршоонд өгсөн. • Хүлэмжийн цогцолбор аж ахуйн 1.5 га ил талбайд 12 төрлийн ургамлын үр үржүүлгийн болон товарын ургацын туршилт, 15 хүлэмжид 7 төрлийн хүнсний ногооны үр үржүүлэг, говьд ургадаг мод, бутны үржүүлэг, говьд ургадаг эмийн ургамлын үржүүлэг, 5 хүлэмжинд 4 төрлийн хүнсний ногоо, 1 өвлийн хүлэмжид гоёл чимэглэлийн цэцэг, 1 өвлийн хүлэмжийг үрслэгийн үйлдвэр байдлаар тохижуулсан. Нийт хүлэмжийн 5700 м.кв бүхий хүлэмжийн талбайгаас 7.2 тн хүнсний ногоо, мөн ил талбайд 	90

				<p>таригдсан 5 төрлийн үр үржүүлгийн таримлаас 0.8 тн үр хураан авсан.</p> <ul style="list-style-type: none"> • Аяны хүрээнд 4 удаагийн сургалт арга хэмжээнд 21 агрономич, 200 газар тариалан эрхлэгчид хамрагдсан байна. 2020 онд 2264м.кв талбай бүхий хүлэмжийг иргэдэд олгож, 2 суманд 3 хүлэмжийг нэмж ашиглалтад оруулснаар нийт 3684 м.кв-аар хүлэмжийн тариалалтын талбай нэмэгдсэн байна. 2020 онд нийт 5700м.кв хүлэмжийн талбайгаас 7.2 тн хүнсний ногоо, мөн ил талбайд таригдсан 5 төрлийн үр үржүүлгийн таримлаас 0.8 тн үр хураан авсан байна 	
10	2021 онд тариалах үрийн нөөцийг бүрдүүлэх	2020 оны ургацаас үрийн нөөц бүрдүүлнэ	Тариалах талбайн 90-ээс багагүй хувьд үрийн нөөц бүрдүүлэх	<ul style="list-style-type: none"> • Аймгийн хэмжээнд 2020 онд төмс 61.6 га талбайд, хүнсний ногоо 105.03 га талбайд, тэжээлийн ургамал 72.4 га талбайд, жимс, жимсгэнэ 35.5 га талбайд нийт 274.5 га талбайд тариалалт хийж нийт 1810 тн ургац хураан авсан. • Даланзадгад сумын "Хүлэмжийн цогцолбор аж ахуйн талбай"-д таригдсан 5 төрлийн үр үржүүлгийн таримлаас 0.8 тн үр хураан авсан ба Хүлэмжийн цогцолбор аж ахуйн талбайд "Сургалтын төв"-ийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтад оруулан иж бүрэн техник хэрэгслээр хангасан бөгөөд, цаашид өргөжүүлэн говийн бүсийн үр үржүүлгийн төв болгон хөгжүүлэхээр ХХААХҮЯ болон орон нутгийн дээд шатны байгууллагуудтай хамтран ажиллаж байна. • Төмс, хүнсний ногооны хадгалалт, нөөцлөх боломжийг бүрдүүлэн орон нутгийн хүн амын төмс хүнсний ногооны хангамжийг сайжруулах зорилгоор механикжсан зоорийг "Төгөлдөр Ананд" ХХК-д 10 жилийн хугацаатай менежментийн гэрээгээр эзэмшүүлсэн. Тус зооринд 105 тн төмс, хүнсний ногоо хадгалалтад оруулсан бөгөөд үнийн хөөрөгдөл үүсгэхгүй хангамжийг тогтвортой байлгах зорилгоор 40 хувийн хямд нөхцөлөөр төмс, хүнсний ногоог борлуулж байна. • Аймгийн хэмжээнд 88 зоорь агуулах /757,5 м.кв/ бүртгэлтэй байгаа бөгөөд тус зоорь агуулахыг 100 паспортжуулсан. • 2020 онд нийт 5700м.кв хүлэмжийн талбайгаас 7.2 тн хүнсний ногоо, мөн ил талбайд таригдсан 5 төрлийн үр үржүүлгийн таримлаас 0.8 тн үр хураан авсан байна. 	80
Хүнс худалдаа, нийтийн хоолны салбарын чиглэлээр					
11	Аймг, орон нутгийнхаа хэмжээнд хүн амын стратегийн хүнсний улирлын нөөцийг	Орон нутгийн хэмжээнд хүн амын стратегийн хүнсний улирлын нөөцийг бүрдүүлэх ажлыг	2020 онд боломжит нөөц бүрдүүлсэн байна	<ul style="list-style-type: none"> • Даланзадгад сумын 2020 оны хавар, зуны хэрэгцээг хангах, үнэ тогтворжуулах зорилгоор нөөцийн мах бүрдүүлэх төсөл сонгон шалгаруулж "Өнөд өвлөх урлахуй" ХХК, "Хан сайхан говь" ХХК шалгаран 100 тн махны нөөц бүрдүүлсэн. Нөөцийн махыг 3 дугаар сарын 27-ны өдрөөс 6 сарын 26 хүртэл Даланзадгад сумын 16 цэг 	100

	бүрдүүлэх ажлыг зохион байгуулах	сайн зохион байгуулсан		<p>/дэлгүүр/-ээр борлуулалт хийх гэрээ байгуулж, Үхрийн мах 8300, хонины мах 7300 төгрөг, ямааны мах 6300 төгрөгөөр зах зээлд борлууллаа. Энэхүү борлуулалт нь зах зээлийн үнээс 1500-2000 төгрөгөөр хямд бөгөөд худалдан борлуулсан махны килограмм тутамд 1000 төгрөгийн урамшуулал, нийт 100.0 сая төгрөгийн урамшууллыг орон нутгийн төсвөөс олгоод байна. Үүний үр дүнд хүн амын хавар зуны улирлын махны хэрэгцээний 15 хувийг хангаж, үнийг тогтворжуулан ажилласан.</p> <ul style="list-style-type: none"> • 2021 оны хавар зуны улирлын Өмнөговь аймгийн хүн амын махны хэрэглээний нөөц бүрдүүлэх зорилгоор нөөцийн мах бэлтгэх аж ахуйн нэгжийг шалгаруулах сонгон шалгаруулалтыг зарлаад байна. 	
12	"Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн" дэд хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх	Засгийн газрын 2019 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн" үндэсний хөтөлбөрийн 5.4-д аймгууд дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх тухай заасан	дэд хөтөлбөрийн хэрэгжилт 20%-д хүрсэн байна	<ul style="list-style-type: none"> • "Эрүүл хүнс-Эрүүл Монгол" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2020 оны төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлан 100 хувь хэрэгжүүлэн ажиллалаа. • Хөтөлбөрийн хүрээнд "Цагаан сар" арга хэмжээний үеэр 130 гаруй бизнес эрхлэгч аж ахуй нэгж, иргэдийг хамруулан сургалт зохион байгуулсан. "Оюу толгой" ХК-д "Гүүд рүүт интер трейд", "Өнөд Өвлөхүй Трейд" ХХК-тай мах, махан бүтээгдэхүүн нийлүүлэх, "Төгөлдөр Ананд" ХХК-тай хүнсний ногоо нийлүүлэх гэрээг байгууллаа. Уул уурхайн салбарт ханган нийлүүлдэг хүнсний бүтээгдэхүүний хэмжээ 2019 оны 4 дүгээр сараас 2020 оны 9 сар хүртэл хугацаанд мах, махан бүтээгдэхүүн 197 тонн, хүнсний ногоо 1,175 тонн болж нэмэгдсэн байна. • "Төгөл" хүнсний үйлдвэр 2020 онд "ЖДҮ-ийг чадавхжуулах" хамтарсан хөтөлбөртөөс дэмжлэг авч, чацарганы тос үйлдвэрлэж эхэлсэн. ЖДҮДСангийн зээлд сүү, сүүн бүтээгдэхүүн, цэвэр ус үйлдвэрлэл, дайвар бүтээгдэхүүн үйлдвэрлэл хүнсний ногоо боловсруулах савлах, хатаах зэрэг хүнсний үйлдвэрлэл эрхэлдэг 5 аж ахуй нэгж хамрагдаж, нийт 360 сая төгрөгийн санхүүжилтээр өргөжүүлэн 8 шинэ ажлын байр бий болсон. • "Өглөөний цай" болон "Ээжийн сонголт – Эрүүл хүнс" "Дархлаа дэмжих уламжлалт хоол" зэрэг цуврал хоолны 10 нэвтрүүлэг, контентийг бэлтгэн Мэлмий.мн сайтаар дамжуулан 7 хоног бүр 1 удаагийн давталттайгаар иргэдэд сурталчилсан. • Короновируст /Ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, аймаг, сумдын хүнсний бараа, мал махны ачаа тээврийн хөдөлгөөнийг зохицуулах түр журмыг сумдын ХААТасаг, хүнсний үйлдвэрлэл эрхлэгч, хүнс тээврийн жолооч нарт хүргүүлэн ажиллаж байна. Авто тээврийн үндэсний төвийн нэгдсэн програмаас QR код олгон, 38 тээврийн хэрэгсэл аймаг, хот хооронд хүнс, барааны тээвэрлэлт хийж байна. 	100

				<ul style="list-style-type: none"> • Өвөлжилтийн бэлтгэх хангах, малчдын мал махыг зах зээлд борлуулах ажлын хүрээнд ХХААХҮЯамтай бодлогын гэрээ байгуулсан Ду-юан-хаа ХХК, Ихэр шурангад ХХК-тай орон нутгийн 2 хоршоо, 1 аж ахуй нэгж гэрээ байгуулан 90 тн мах орон нутгийн зах зээлээс бэлтгэн нийлүүлээд байна. 	
13	"Мах, сүүний анхдугаар аян"-ны хүрээнд орон нутагт хэрэгжүүлж байгаа батлагдсан төлөвлөгөөнд туссан удаашралтай байгаа ажлыг эрчимжүүлэх	2019 оны төлөвлөгөөний хэрэгжилт 50-70% байна. Хэрэгжилт удаашралтай, хангалтгүй байгаа ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна	Төлөвлөгөөний хэрэгжилт 100%-д хүрсэн байна. Аяныг дүгнэсэн эцсийн тайланг хугацаанд нь ирүүлэх	<ul style="list-style-type: none"> • Аяныг хэрэгжүүлэх аймгийн 4 жилийн төлөвлөгөөг Засаг даргын 2017 оны А/579 тоот захирамжаар батлуулан хэрэгжүүлж байна. Аяны хүрээнд төсвийн болон хувийн хөрөнгө оруулалтын нийт 3,8 тэрбум төгрөгийн санхүүжилтээр мах боловсруулах үйлдвэр байгуулагдсан. Тус махны үйлдвэр нь 250 тонн мах нөөцлөх чадамжтай бөгөөд хоногт 50 бод, 150 бог мал нядлах, толгой шийр, гэдэс ялгах, сэврээх, хөлдөөх, гэсгээх, хөргүүр бүхий зориулалтын өрөө, лаборатори, бууз, банш, хиам үйлдвэрлэх зориулалттай үйлдвэр юм. • Орон нутгийн мах, сүүний үйлдвэрлэл нэмэгдүүлэх, энэ чиглэлийн үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих зорилгоор ангилсан махны цех 2, ингэний сүү боловсруулах 3 үйлдвэр /цех/ шинээр байгуулах болон үйл ажиллагаагаа өргөтгөхөд зориулан Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас 463 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгоод байна. Эдгээр үйлдвэрлэлийг дэмжсэнээр 11 ажлын байр шинээр бий болгож, мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл 5 хувь, сүүний үйлдвэрлэл 3 хувиар өссөн байна. • 2020 оны 09 сараас Хорио цээрийн дэглэм цуцлагдсан үед 6 сум үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, 150 гаргуй иргэн, аж ахуйн нэгж оролцон, 46.5 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна. • Даланзадгад сумын 2020 оны хавар, зуны хэрэгцээг хангах, үнэ тогтворжуулах, хомстол үүсэхгүй байх зорилгоор төсөл сонгон шалгаруулж, 2 аж ахуй нэгж шалгаран 100 тн махны нөөц бүрдүүлсэн. 2020 оны 3 дугаар сараас 6 сарын 25 хүртэл хугацаанд хонины мах - 7300 кг/ төг, ямааны мах -6300 кг/ төг, үхрийн мах 8300 кг/төгтөгөөр борлуулж, зах зээлийн үнээс 1500-2000 төгрөгөөр хямд, хонины мах 30тн, үхрийн мах-20 тн, ямааны мах- 50 тн борлуулж, үнийг тогтворжуулсан. Даланзадгад сумын хаврын хэрэгцээний 20 хувийг хангаж, аж ахуй нэгжүүдэд 1 кг тутамд 1000 төгрөгийн нийт 100.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. • 2021 оны хавар зуны улирлын Өмнөговь аймгийн хүн амын махны хэрэглээний нөөц бүрдүүлэх зорилгоор нөөцийн мах бэлтгэх аж ахуйн нэгжийг шалгаруулах сонгон шалгаруулалтыг зарлаад байна. Уг сонгон шалгаруулалтад тэнцсэн аж ахуйн нэгжүүдээр 200 тонн мах бэлтгүүлэхээр төлөвлөөд байна. • Аяныг хэрэгжүүлэх 2020 оны төлөвлөгөө 100% хэрэгжсэн байна. 	100

14	<p>Хоол, үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны салбарт шинээр батлагдсан эрх зүйн баримт бичгийг сурталчлах, мөрдүүлэх ажлыг нутгийн Мэргэжлийн хяналтын газартай хамтран зохион байгуулах</p>	<p>2019 онд "Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт тавигдах шаардлага MNS4946:2019 стандартыг баталж, 2019 оны 9 сарын 01-нээс мөрдөж эхэлсэн. Мөн "Кейтеринг үйлчилгээнд тавих шаардлага", "Хоолны газрын хүнсний нөөцөд тавих шаардлага" стандартын төслийг боловсруулан батлуулахаар СХЗГ-т хүргүүлсэн.</p>	<p>2-оос доошгүй удаагийн сургалт явуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлыг аймаг орон нутгийн төвшинд зохион байгуулж, үр дүнг тайлагнасан байна.</p>	<ul style="list-style-type: none"> • Аймгийн тогоочдын холбоо, Стандартчилал хэмжилзүйн хэлтэстэй хамтран 10 сумын сургууль, цэцэрлэгийн 22 тогоочийг хамруулан "Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрын стандартыг сурталчлах нь" сургалтыг Даланзадгад суманд зохион байгуулж, сургууль, цэцэрлэгийн 15 тогоочийн зэргийг ахиулсан. • Мэргэжлийн хяналтын газартай хамтран 2020-2021 оны хичээлийн жил онцгой нөхцөлд эхэлж байгаатай холбогдуулан аймгийн нийт 53 боловсролын сургалтын байгууллагын захирал, эрхлэгч, сургалтын менежер, арга зүйч, тогооч нарт "ЕБС-ын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай" хуулийн танилцуулга сургалтыг зохион байгуулж 218 хүн оролцсон. • 2020 онд хоол үйлдвэрлэлийн үйлчилгээнд тавигдах дүрэм журмыг сурталчлан таниулах сургалт, арга хэмжээг 2 удаа зохион байгуулж, нийт 75 байгууллагын төлөөлөл 240 хүн оролцсон байна. 	100
15	<p>2020 оныг "Мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нөөцийн ашиглалт, экспортыг нэмэгдүүлэх" жил болгон зарласантай холбогдуулан иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын оролцоотой мал аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх бүтээлч ажлыг санаачлан зохион байгуулж хэрэгжүүлэх</p>	<p>2020 оныг "Мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нөөцийн ашиглалт, экспортыг нэмэгдүүлэх" жил болгон зарласан.</p>	<p>"Мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нөөцийн ашиглалт, экспортыг нэмэгдүүлэх" жилийн хүрээнд нэгээс доошгүй бүтээлч ажил хийгдэж, экспортын хэмжээ нэмэгдсэн байна</p>	<ul style="list-style-type: none"> • Малын гаралтай түүхий эд бэлтгэлийн чиглэлээр Монголын арьс шир үйлдвэрлэгчдийн холбоотой Өмнөговь аймгийн 5 салбар холбоо, 77 хувь хүн гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. • Аймгийн хэмжээнд түүхий эд бэлтгэлийн мэдээг долоо хоног бүр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон Төрийн банкны Өмнөговь аймаг дахь салбарт хүргүүлж байна. • Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийг бэлтгэх, чанар хамгаалалт, тордолт хийх цэгийг сумдад, малчдын хоршоог түшиглэн байгуулахыг дэмжих зорилгоор "Сум бүрд жишиг хоршоог хөгжүүлж, түүхий эдийн анхан шатны боловсруулалтын цэг байгуулах ажил"-ыг орон нутгийн төсвөөс 294 сая төгрөгийн санхүүжилтээр хийж гүйцэтгэлээ. Уг ажлыг сумдад эрх шилжүүлэн зохион байгуулж, 12 сум арьс шир боловсруулах цех 7, арьс нэхий боловсруулах цех 2, эсгийний үйлдвэр 2, арьс үслэг эдлэл боловсруулах цех 1, нийт 12 анхан шатны цех, үйлдвэрт дэмжлэг үзүүлэн үйл ажиллагааг эхлүүлээд байна. • Мөн "Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих, жижиг дунд үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж" худалдан авах ажиллагааг 9 сум зохион байгуулж, 13 төрлийн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг нийлүүлэн, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг явуулж байна. Малын гаралтай түүхий эд боловсруулах ажлыг зохион байгуулах иргэн, аж ахуйн нэгжүүдтэй ХХААГ-ын мэргэжилтэн биечлэн уулзаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд бэлтгэх, боловсруулах чиглэлээр давхардсан 	70

				тоогоор 15 суманд 25 цех үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг нийлүүлэн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг явуулж байна.	
Хөнгөн үйлдвэрийн салбарын чиглэлээр					
16	Засгийн газрын 2018 оны 36 дугаар тогтоолд тусгагдсан үйлдвэрүүдийг байгуулах ажлыг эрчимжүүлэх	21:100 хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн ажлын талаарх мэдээллийг хавсаргав	Хөтөлбөрт тусгагдсан үйлдвэрүүд баригдаж ашиглалтад орсон байна	<ul style="list-style-type: none"> Орон нутагт жижиг дунд үйлдвэрийг кластераар хөгжүүлэх замаар нэмүү өртөг шингэсэн, өрсөлдөх чадвартай, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд "Ингэний сүү боловсруулах үйлдвэр"-ийн техник эдийн засгийн үндэслэл, үйлдвэрийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийн зураг төсөв боловсруулах ажлыг гүйцэтгүүлсэн. Тус үйлдвэрийн ТЭЗҮ-ийн суурь судалгаагаар "Ингэний сүү боловсруулах үйлдвэр"-ийн байршлыг Даланзадгад суманд байх нь оновчтой гэж дүгнэсний дагуу тус Даланзадгад сумын шинэ суурьшлын бүсийн үйлдвэрлэлийн районд 3 га газар олгогдоод байна. Даланзадгад суманд байгуулагдах хоногт 2 тонн тэмээний ноос боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулан хүлээн авсан. 	50
17	Төрийн худалдан авалтад дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх ажлыг удирдан зохион байгуулах	Төрийн худалдан авалтад дотоодын үйлдвэрийн нийлүүлэлт хангалтгүй байна	Төрийн худалдан авалтад дотоодын үйлдвэрийн нийлүүлэлт урьд оныхоос өссөн байна	Өмнөговь аймгийн хэмжээнд Төрийн худалдан авах ажиллагаанд дотоодын үйлдвэрлэлийг бараа бүтээгдэхүүн нийлүүлэхэд анхааран ажиллаж байна. 2020 онд Өмнөговь аймгийн хэмжээнд 184 тендэр зарлагдсанаас 3 нь 100% дотоодын үйлдвэрийн ханган нийлүүлэлт байна. Үлдсэн 181 тендэрийн бараа бүтээгдэхүүний 30% нь дотоодын үйлдвэрийн бараа бүтээгдэхүүн ханган нийлүүлсэн тоон мэдээлэлтэй байна.	100
Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршооны салбарын чиглэлээр					
18	Засгийн газрын 2019 оны 156 дугаар тогтоолоор баталсан "жижиг дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр"-ийн аймгийн дэд хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлэх	Засгийн газрын 2019 оны 156 дугаар тогтоолоор баталсан	Бүх аймгууд дэд хөтөлбөртэй болж, хэрэгжүүлсэн байна	<ul style="list-style-type: none"> Өмнөговь аймгийн хэмжээнд орон нутгийн онцлог, түүхий эдийн нөөцөд тулгуурласан, байгальд ээлтэй, импортыг орлох, экспортын чиг баримжаатай зах зээлийн хэрэгцээнд нийцсэн, тогтвортой үйлдвэрлэлийг хөгжүүлж ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 71 дүгээр тогтоолоор "Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих дэд хөтөлбөр" батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хөтөлбөрийн хүрээнд Орон нутгийн жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийг дэмжих зорилгоор орон нутгийн төсвийн хөрөнгийн 1 тэрбум төгрөгийг ЖДҮХ санд байршуулж орон нутгийн багц бий болгон орон нутгийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд урт хугацаатай хөнгөлөлттэй зээл олгосон. 2020 онд 13 аж ахуй нэгж жижиг, дунд үйлдвэрүүдэд 1.5 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгож, 5 үйлдвэр /531.0 сая төгрөг/ шинээр байгуулагдан, 8 үйлдвэр /914.5 сая төгрөг/ өргөтгөл хийн хүчин 	100

				<p>чадлаа нэмэгдүүлснээр 50 ажлын байр хадгалагдаж, 97 ажлын байр шинээр бий болсон дүнтэй байна.</p> <ul style="list-style-type: none"> • Мөн хөтөлбөрийн хүрээнд Өмнөговь аймаг, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн ЭТИС хөтөлбөр, Говийн оюу хөгжлийг дэмжих сан болон Оюу толгой ХХК хамтран “ЖДҮ-ийг чадавхжуулах” хамтарсан хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа ба энэ хүрээнд хүрээнд орон нутгийн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч, хоршоодыг чадавхжуулах, бизнесийн зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэх зорилгоор Даланзадгад хотод “Бизнесийн инноваци хөгжлийн төв” байгуулсан. "Оюу Толгой" ХХК ханган нийлүүлэгчид болон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг чадавхжуулах сургалт, мэдээлэл, зөвлөгөөг 600 гаруй хүнд хүргээд байна. “ЖДҮ-ийг чадавхжуулах” хамтарсан хөтөлбөрөөс 2020 онд Өмнөговь аймгийн 12 компанид үйлдвэрлэлийн менежмент, 5S хөдөлгөөн, чанарын удирдлага, менежментийн чиглэлээр 26 удаагийн сургалт зохион байгуулж, шинэ мэдлэг, өөрчлөлтийг тухайн аж ахуйн нэгжид хэрэгжүүлэх, хэвшүүлэх, “нутагшуулах” зорилгоор нийт 80 цагийн зөвлөх үйлчилгээ үзүүлсэн байна. • Үүнээс гадна Баяндалай, Гурвантэс, Манлай, Ханбогд, Ханхонгор, Хүрмэн, Цогтцэций сумдууд сум хөгжүүлэх сангаас 414.8 төгрөгийн санхүүжилтээр 38 иргэнд хөнгөлөлттэй зээл олгогдож 27 ажлын байр шинээр бий болсон. 	
19	"Ахуйн үйлчилгээний салбарыг дэмжих хөтөлбөр"-ийн аймгийн дэд хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлэх	Засгийн газрын 2019 оны 362 дугаар тогтоолоор баталсан	Бүх аймгууд дэд хөтөлбөртэй болж, хэрэгжүүлсэн байна	<ul style="list-style-type: none"> • Сумдын "Сум хөгжүүлэх сан"-аас халуун усны газрын засвар үйлчилгээ, дулааны шугам сүлжээнд 286 сая , үсчин, гоо сайхны үйлчилгээнд 10,0 сая төгрөг, модон тавилгын захиалга засварын үйлчилгээнд 14,7 сая төгрөг, гутал засварын үйл ажиллагаанд 35,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл тус тус олгон иргэдэд үйлчилгээгээ хүргэж байна. • Улсын төсвийн 100 сая төгрөгийн санхүүжилтээр Манлай суманд ахуй үйлчилгээний төв, орон нутгийн төсвийн 80.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баян-Овоо суманд 180м2 талбай бүхий ахуй үйлчилгээний төв, Мандал-Овоо суманд 129 сая төгрөгийн санхүүжилтээр ахуй үйлчилгээний төвийг барьж ашиглалтад оруулан, 10 ажлын байрыг бий болгоод байна. • Гурвантэс суманд “Шугшаа уул” ХХК-ний баригдсан төвд түүрээсээр үсчин, гоо сайхан, маникюр, алт мөнгөний дархан, утас засварын үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд нийт 9 ажлын байр бий болгосон. • Аймгийн 15 сумын хэмжээнд сум бүр 4 улирлаар ажилладаг стандартын шаардлага бүхий халуун усны газартай болсон бол 2020 онд шинээр хими цэвэрлэгээ-2, мод модон эдлэл-3, авто 	50

				<p>засвар-4, авто угаалга-2, гар оёдол-4, усан бассейны үйлчилгээ-1 нэмэгдсэн байна. Нийтийн ахуйн үйлчилгээний салбарын үйлчилгээ, үйл ажиллагаа явуулж буй 10 үйлчилгээний цэгт стандартын үнэлгээ хийн гэрчилгээжүүлснээр халуун ус, үсчин гоо сайхан, авто засварын үйлчилгээг иргэд стандартын дагуу үнэлгээ хийгдсэн тохирлын гэрчилгээтэй цэгээс үйлчилгээг авах нөхцөлийг бүрдүүллээ.</p> <ul style="list-style-type: none"> • Аймгийн Засаг даргын Тамгын газар болон бусад мэргэжлийн байгууллагуудтай хамтран ахуйн үйлчилгээний чиглэлээр туршлага судлах арга хэмжээ 1, сургалт, хэлэлцүүлгийг 3 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 140 гаруй ахуйн үйлчилгээ эрхлэгчид хамрагдсан байна. • 2020 онд сум хөгжүүлэх сангаас нийт 333.7 сая төгрөгийг 21 иргэн, аж ахуй нэгжид олгож, улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 3 суманд 309 сая төгрөгний ахуй үйлчилгээний төвүүд барьж ашиглалтад оруулаад байна. 	
20	Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэн хүртээмжийг өсгөх	Аймаг өөрийн дотоод эх үүсвэр бий болгож зээл олгоогүй	Орон нутгийн эх үүсвэрээр жижиг дунд үйлдвэрийг дэмжих хөнгөлөлттэй зээл олгосон байна	<p>Манай аймаг орон нутгийн Жижиг дунд үйлдвэрийг дэмжих дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр 1.0 тэрбум төгрөгийг төсөвлөн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 9/6 дугаар тогтоолоор баталсан.</p> <p>Батлагдсан хөрөнгийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 16 дугаар зүйл, 16.4 дэх хэсгийг үндэслэн Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд төвлөрүүлж, орон нутгийн үйлдвэрлэл эрхлэгчдэд Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу зээл олгож хамтран ажиллаж байна.</p> <p>"Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох журам"-ын дагуу 4 үе шатны шалгаруулалтад тэнцсэн 13 төсөл хэрэгжүүлэгчид орон нутгийн төсвийн 1 тэрбум, улсын төсвийн 0.5 тэрбум нийт 1.5 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгогдсон байна. 2020 онд 8 салбарын 13 аж ахуй нэгжид 1.5 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосноор 5 үйлдвэр шинээр бий болж, 8 үйлдвэр өргөтгөл хийн 50 ажлын байр хадгалагдаж, 97 ажлын байр шинээр бий болсон.</p>	100
21	ХЖҮХСангаас хуваарилсан зээрийн эх үүсвэрийг бүрэн гүйцэд ашиглах, 2019 онд олгосон зээлийн үр дүн, хэрэгжилтийг журмын дагуу	Журмын хэрэгжилт хангалтгүй байсан	ЖДҮХС-аас хуваарилсан хөрөнгийн санхүүжилт 100% байх, 2019 онд олгосон зээлийн үр дүнгийн хэрэгжилт 30%-д хүрсэн байх	<p>Засгийн газрын 2020 оны 113-р тогтоолоор батлагдсан "Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох журам"-ын дагуу 4 үе шатны шалгаруулалтад тэнцсэн 13 төсөл хэрэгжүүлэгчид орон нутгийн болон улсын төсвийн 1.5 тэрбумын төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгогдсон байна. 2019 оны 10 иргэн, аж ахуй нэгж, 2020 онд 13 аж ахуй нэгж жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх хөнгөлөлттэй зээлд хамрагдсанаар 906.0 сая төгрөгийн төсвөөр жижиг дунд үйлдвэрлэлийн 7 үйлдвэр шинээр байгуулагдаж, 1.5 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 16 үйлдвэрлэл</p>	100

	хугацаанд тайлагнах	нь			<p>өргөтгөл хийсэн байна. 2019 онд ЖДҮХС-аас 5 иргэн, 5 аж ахуйн нэгж, 1.0 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан бөгөөд 6 иргэн, аж ахуйн нэгжийн үйлдвэрийн үйл ажиллагаа нь бүрэн ажиллаж байгаа бол Ковид -19 цар тахалаас сэргийлэх хорио дэглэмийн улмаас 4 иргэн, аж ахуйн нэгжийн үйлдвэрлэл, үйл ажиллагаа бүрэн ажиллахгүй байна. ЖДҮХС-аас хуваарилсан 500 сая төгрөгийн санхүүжилтийг "Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгох хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын дагуу шаардлага хангасан 3 аж ахуй нэгжид 100 хувь олгосон. ЖДҮХС-аас 2019 онд 5 иргэн, 5 аж ахуй нэгжид олгосон 1 тэрбум төгрөгийн зээлийн үр дүн, хэрэгжилт 69%-тай байна.</p>	
Бусад арга хэмжээ						
22	Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2018-2019 оны, Мал эмнэлгийн газрын 2019 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд бүрэн хэмжээний санхүүгийн хяналт шалгалт хийх	Санхүүгийн хяналт шалгалт хийгдээгүй	Санхүүгийн хяналт шалгалтын дүнг аймгийн Засаг даргын дэргэдэх Дотоод аудитын хороогоор хэлэлцүүлж, Дотоод аудитын хорооны тогтоол, нэгдсэн болон нэг бүрчлэн акт, албан шаардлага, дүгнэлт, холбогдох судалгааны хамт Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яаманд ирүүлэх	<ul style="list-style-type: none"> Засаг даргын дэргэдэх Санхүү, хяналт аудитын алба 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрөөс 06 дугаар сарын 25-ны өдрийн хооронд аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2018-2019 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн 2020 оны 06 сарын 25-ны өдрийн 63 дугаар бүхий Санхүүгийн хяналт, аудитын албаны хяналт шалгалтын танилцуулга ирүүлсэн. Уг хяналт шалгалтаар Говийн дэмжлэг хөтөлбөрийн нэмэгдэл илүү тооцож олгосон, төсвийг батлагдсан эдийн засгийн ангилалын дагуу зарцуулаагүй, цалингийн сангаас шагналын дагалдах мөнгөн шагнал олгосон, албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин илүү олгосон, үр дүнгийн мөнгөн урамшуулал илүү олгосон, ажилчдын ангилал, зэрэглэл зөрүүтэй тооцож, илүү цалин олгосон, шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан зэрэг зөрчил илрүүлсэн байна. Зөрчил арилгуулах албан шаардлагын дагуу зөрчлийг бүрэн арилгаж, дахин зөрчил гаргахгүй байх арга хэмжээг авч, 1690524 төгрөгийг төсвийн орлогод бүрэн төвлөрүүлж ажилласан байна. Мал эмэнэлэг 	100	
23	Салбарын бүх тайлан мэдээ, хөтөлбөрийн хэрэгжилтэд хүнтэй холбоотой мэдээлэл туссан тохиолдолд хүйсээр ангилан харуулж байх	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн хүрээнд гаргасан ХХААХҮ-ийн Сайдын 2018.05.17-ны өдрийн А-94 тоот тушаалаар ХХААХҮ-ийн салбарт жендэрийн талаар	Мэдээллийг хүйсээр ангилж харуулсан байна	<ul style="list-style-type: none"> Аймгийн Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийн хүрээнд Хүнс, хөдөө аж ахуйн салбарын хүйсийн судалгаа хийх ажлыг 2020 оны 11 сард сумдын Хөдөө аж ахуйн тасагтай хамтран зохион байгууллаа. Энэхүү судалгааны ажилд нийт 10 төрлийн хүнтэй холбоотой хүйсийн судалгаа мэдээллийг нэгтгэн мэдээллийн сантай болсон. Өмнөговь аймгийн хэмжээнд 21097 өрх байгаагаас 6108 малчин өрх байна. 9761 малчдаас 4237 буюу 43.4% нь эмэгтэй малчин байна. 2019 оны аймгийн аварга малчин 7 өрхөөс 1 өрх нь өрх толгойлсон эмэгтэй байна. 	100	

		баримтлах бодлого батлагдсан болно		<ul style="list-style-type: none"> • 2019 онд Говийн Оюу хөгжлийг дэмжих сангийн санхүүжилтээр Оюу хүлэмжийн Говийн оюу хөгжлийг дэмжих сангийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй "Оюу хүлэмж" төслийн хүрээнд 2020 онд аймгийн хэмжээний 15 сумын 97 газар тариалан эрхлэгчдэд "Зуны нийлэг хальсан хүлэмж"-ийг хөнгөлөлттэй нөхцөлөөр олгосон. Энэхүү төсөлд хамрагдсан тариалан эрхлэгчдийн 74% нь буюу 72 нь эмэгтэй тариаланч байлаа. 	
	Дундаж үнэлгээ				87%